



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,


Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.07.05 № СЭ-112-12/4691
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн
тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Шахуургын сэлбэг хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102234 дугаартай тендер (НТШ) шалгаруулалтад оролцсон Апейро ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яам 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 03/5788 дугаар албан бичгээр хуулийн 59.6 дахь хэсгийг үндэслэн гүйцэтгэгч сонгох ажиллагааг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн болохыг үүгээр мэдэгдье.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨЛӨВЛӨЛТ,
МОНИТОРИНГИЙН АЛБАНЫ ДАРГА  Т.АРИУНШАН



ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407017959



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот.
Утас/факс: (976-51) 26 74 68. Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.07.05 № 03/5788
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/20240102234 дугаартай “Шахуургын сэлбэг хэрэгсэл нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Апейро” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу бусад оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766010503